

## ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ЗӨВЛӨМЖ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

ХХЗХ-ны дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд тус байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийсний үндсэн дээр эрсдэлтэй гэж үзсэн процессуудад дотоод аудит хэрэгжүүлэхээр тусгадаг бөгөөд ХХЗХ-ны даргын баталсан жилийн төлөвлөгөөг “Дотоод аудитын үйл ажиллагаа хэрэгжүүлэх” журмын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, хэрэгжилт дутуу байгаа зөвлөмжүүдийг дүгнэлт, сайжруулах зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

дд	Дотоод аудитын ажил	Зөвлөмж	Эрсдэл/Тайлбар
1	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах ажиллагаа (процесс)-нд аудит хийж, дүгнэлт гаргах, зөвлөмж хүргүүлэх	Тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, үйл ажиллагааны түүхэд үндэслэж сунгадаг байх (Шат дараатай хэрэгжүүлэх)	Сунгалт нь хамгийн багадаа 3, ихдээ 20 жилийн үйл ажиллагаанд үнэлэлт өгөх үйл ажиллагаа бөгөөд ТЗ-ийн хугацаа сунгахад зөвхөн тухайн жилд үнэлэх зарчим барих нь хэрэгжилт хангуулах чиг үүргийн ач холбогдлыг бууруулах эрсдэлтэй. Гэрээний үүргийн хэрэгжилт дүгнэж, тусгай зөвшөөрөлт үйл ажиллагааны талаар түүх үүсгэж, нэгдсэн мэдээллийн сантай болох нь хэрэгжилтийн хангуулах (regular) ажлын үр нөлөөг дээшлүүлэх, тухайн үеийн үнэлэгчийн субъектив хандлагаас ангид байх ач холбогдолтой.
2	Хорооны хуралдааны шийдвэр гарах процесс (ХХ болон ажлын албад хоорондын хамаарал)-т шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, танилцуулах	Захиргааны хэм хэмжээний акт боловсруулан батлуулах, бүртгүүлэх процесс, алхмуудад тавигдах шаардлага тодорхой болгох	Ажил үүргийн заагийг тодорхой болгох, захиргааны ерөнхий хуульд заасны дагуу нийтлэг шаардлагыг удирдлагын зүгээс тавих, зохицуулалтын баримт бичгийн чанар, хэрэгжихүйц байдлыг дээшлүүлэх ач холбогдолтой.
3		Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдал, батлагдсан баримт бичгүүдийн хэрэгжилттэй холбоотой гомдол санал гэх мэт тодорхой гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тогтож, зорилтот түвшин авах, тодорхой хугацаанд, тайлагнаж ажиллах	Хорооны хуралдаан болон ажлын албаны хоорондын уялдаа сайжрах, шийдвэрийн чанар сайжрах ач холбогдолтой
4	ХХЗХ-ны ажилтан албан хаагчдын улирлын ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг	Төлөвлөгөөт ажлын үнэлгээнд эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх	Төлөвлөгөөт ажлын үнэлгээнд эзлэх хувь бага, цаг үеийн ажил нь ажлын байр бүрд харилцан адилгүй байхад нийтээр нь ижил хувиар тооцож байгаа нь процессын үр нөлөөг бууруулж байна.

5	<p>үнэлэх процесст дотоод аудит хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж хүргүүлэх</p>	<p>Дотоод ажлын хэсгийг ХН-ийн ажилтнаас гарах өгөгдөл дээр үндэслэн шууд удирдлага үнэлэх</p>	<p>Дотоод ажлын хэсгийг Хүний нөөцийн ажилтан үнэлж байгаа нь учир дутагдалтай</p>
6		<p>Ажилтны ажлын цагийн хоцролтын KPI-г үр дүнг удирдахуйц KPI руу шилжүүлэх</p>	<p>Ажилтны ажлын цагийн хоцролт нь "ХХЗХ-ны ажилтан, албан хаагчдын цагийн бүртгэл, цаг ашиглалтад хяналт тавих журам"-аар зохицуулагдаж байхад өөр журмаар давхар KPI авсан зөрчилтэй.</p>
7		<p>Бүтээлч ажил гэж юуг ойлгох юу ойлгохгүйг зааглах, сайжруулсан, санаачилга гаргасан агуулгаар өөрчлөх</p>	<p>Бүтээлч сэтгэлгээний чиглэлээр хийсэн ажлууд ихэвчлэн ажлын байрны тодорхойлолтоор хийгдэж өдөр тутмын ажлууд үнэлэгдсэн байгааг цэгцлэх</p>
8		<p>Ажлын хэсгийн оролцоог ажлын хэсгийн ахлагч үнэлэх</p>	<p>Ажлын хэсгийн ажлыг ажлын хэсгийн ахлагч бус газрын дарга нар үнэлж байгаа нь зөрчилтэй</p>
9		<p>Журмын 4.3-т заасан ярилцлагыг хэвшүүлэх</p>	<p>Тухайн улирлын төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд ямар асуудал байсан, ямар бодит прогресс бий болсныг ажилтантайгаа ярилцах нь цаашдын үр дүнг сайжруулах ач холбогдолтой</p>
10		<p>Газрын дарга болон шууд удирдлагын хяналт, манлайлал, оролцоогоо сайжруулах</p>	<p>Газрын дарга нар болон шууд удирдлагын үр ашигтай хяналт хэрэгжүүлснээр процессын үр дүн, үр нөлөөг сайжруулах</p>